



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 03 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар Х.917
627

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ,
Н.АМАРЗАЯА, Б.БАТТӨМӨР, Д.ОЮУНХОРОЛ,
Д.ЭРДЭНЭБАТ НАР ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай”
Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийн явцын талаар
Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг холбогдох
байгууллагаар бэлтгүүлэн үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын Хайд
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ, Н.АМАРЗАЯА, Б.БАТТӨМӨР,
Д.ОЮУНХОРОЛ, Д.ЭРДЭНЭБАТ НАРЫН МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулт 1. Тогтвортой хөгжлийн зорилтот тусгагдсан Монгол Улсын хөгжлийн үндсэн зорилт болох эдийн засгийг төрөлжүүлж, олон тулгууртай болгох зорилтын хэрэгжилтийн талаар.

Хариулт. “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1-д заасан эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд эдийн засгийг төрөлжүүлэх, олон тулгуурт болгох чиглэлээр Засгийн газраас дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, экспортыг нэмэгдүүлэх импортыг орлох томоохон төслүүдийг эрчимжүүлэх хүрээнд:

1.1 Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангаж, шатахууны гадаад зах зээлээс хамааралтай байдлыг бууруулах чиглэлээр газрын тосны үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Дорноговь аймагт барихаар Засгийн газар шийдвэрлэсэн. Төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг БНЭУ-ын төрийн өмчит “Инженерс Индия лимитед” компани гүйцэтгэж байгаа бөгөөд одоогоор судалгааны ажил 60 хувьтай явж байна. Засгийн газрын зүгээс үйлдвэрийн барилгын ажлыг 2018 онд багтаан эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үйлдвэр ашиглалтад орсноор жилд 1 тэрбум орчим ам.долларын гадагшлах урсгалыг зогсоож, шинээр 500-600 байнгын ажлын байр бий болж, импортын хараат байдлыг арилгахаар тооцоолж байна.

1.2. Барилга, хүнд үйлдвэр, эдийн засгийн суурь бүтэц болох ган бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, импортын хамаарлыг бууруулах төслийг эрчимжүүлж байна. Энэ хүрээнд жилд 100 мянган тонн ган арматур үйлдвэрлэх хүчин чадалтай ган, төмөрлөгийн үйлдвэрийг “Бэрэн групп” ХК нь Эрдэнэт хотод хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барьж байна. Үйлдвэрийн төсөлд Хөгжлийн банкнаас 56.4 тэрбум төгрөгийн зээлийг олгохоор дэмжин ажиллаж байна. Үйлдвэрийг 2018 оны 5 сард ашиглалтад оруулахаар төлөвлөсөн бөгөөд ингэснээр ган арматурын импортын хэмжээ 30-40 хувь буурч, валютын гадагшлах урсгал багасч, барилгын гол үндсэн түүхий эдийн үнэ тогтвортой байх нөхцөл бүрдэхээр байна. Мөн жилд 350 мянган тонн ган бүтээгдэхүүн, үүнээс арматур 200,000 тн, төмөр утас 10,000 тн, ган бөмбөлөг 50,000 тн үйлдвэрлэх хүчин чадалтай Дарханы хар металлургийн төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд нийт 300 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийгээд байгаа бөгөөд Төмөртэй, Төмөртолгойн ордуудад ил уурхай нээж шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, машин механизм, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэж, нойтон соронзон баяжуулах үйлдвэр, Төмөртэйд хуурай соронзон баяжуулах үйлдвэр, Төмөртолгойд хуурай соронзон баяжуулах үйлдвэр,

Төмөртэйн ордыг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг гүйцэтгээд байна. Төслийн хүрээнд шинээр байнгын 800 ажлын байр бий болж, ган төмөрлөгийн импортын хэмжээг 50-60 хувиар бууруулах боломж бүрдэнэ.

1.3. Зэсийн баяжмалыг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар экспортын хэмжээ, валютын орох урсгалыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд жилд 1 сая тонн зэсийн баяжмал боловсруулж, 257.2 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг Өмнөговь аймгийн Ханбогд суманд барьж байгуулахаар Засгийн газар шийдвэрлэсэн. Төслийн хүрээнд 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэж, 500 гаруй ажлын байр шинээр бий болох тооцоо гарсан. Засгийн газраар хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, холбогдох судалгаа хийх ажлуудыг хэрэгжүүлж байна.

1.3. Угсармал барилгын үйлдвэрийг хөгжүүлэх замаар барилгын материалын импортын хэмжээ болон барилгын салбарын өртөг, зардлыг бууруулах арга хэмжээг авч байна. Энэ хүрээнд жилд 250,000 м.кв ашигтай талбай үйлдвэрлэх хүчин чадалтай байшин үйлдвэрлэх комбинатыг Хөгжлийн банкны зээл болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулаад байна. Тус үйлдвэр нь улирал харгалзахгүй үйл ажиллагаа явуулах бөгөөд барилгын материалын импортын хэмжээг бууруулах, шинээр 300 хүний байнгын ажлын байр бий болох боломж бүрдэнэ.

2. Уул уурхайн бус салбарын экспортын орлогыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх хүрээнд:

2.1. Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимжүүлж, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, хүнсний импортын хэмжээг бууруулж, иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Сүүний импортын хэмжээг эрс бууруулах, сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар бүрэн хангах зорилтын хүрээнд хоногт 1.5 тонн шингэн сүү хүлээн авах хүчин чадалтай хуурай сүүний үйлдвэрийг Хөвсгөл аймгийн Их-Уул суманд 2017 оны 6 дугаар сарын 24-ний өдөр ашиглалтад оруулснаар, үйл ажиллагаа нь жигдэрч, хэвийн ажиллаж байна. Мөн дараагийн ээлжийн үйлдвэрүүдийг Хэнтий аймгийн Баянхутаг, Сэлэнгэ аймгийн Ерөө, Дорнод аймгийн Баян-Уул, Баян-Дун, Дундговь аймгийн Өлзийт, Говь- Алтай аймгийн Эрдэнэ, Баянхонгор аймгийн Бууцагаан, Өвөрхангай аймгийн Богд, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Булган аймгийн Хутаг-Өндөр, Дархан- Уул аймгийн Шарын гол сумуудад суурилуулахаар төлөвлөж байгаа бөгөөд барилгын ажлыг бүрэн дуусгаад байна.

Манай улсын хуурай сүүний жилийн импорт 4,100 тонн байгаагаас ойрын хугацаанд хуурай сүүний үйлдвэрүүдийг ашиглалтад оруулснаар импортын хэмжээг 1,000-аад тонноор бууруулах боломжтой болж, шинээр 250 хүний байнгын ажлын байр бий болохоор байна. Цаашид дунд, урт хугацаанд хуурай сүүний импортын хэмжээг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилтыг тавин ажиллаж байна. Мөн шинэ ургацын хүнсний ногооны тариалалт, ургацын хэмжээг нэмэгдүүлэх замаар импортын хэмжээг бууруулах бодлого баримталж байна. 2017 оны улсын төсвийн тодотголоор 6.9 га талбай бүхий нийт 720 ширхэг

хүлэмжийг 4 жилийн хугацаатайгаар аймаг, нийслэлийн ногоочдод олгох төсөв батлагдсан. Нийт өртөг нь 1.65 тэрбум төгрөг бөгөөд ингэснээр одоогийн хүлэмжийн ногооны 5,400 тонн хүчин чадлын хэмжээ 1,000 гаруй тонноор нэмэгдэх боломж бүрдэх юм. Мөн 2018 оны төсөвт 1.98 тэрбум төгрөгийг хүлэмж барихад тусгасан бөгөөд тус онд 800 ширхэг хүлэмжийг 330 суманд олгосноор хүлэмжийн ногооны хүчин чадал 1,100 тонноор нэмэгдэхээр тооцоолсон. Одоогоор манай улс нийт хүлэмжийн ногооны хэрэглээнийхээ 10-аад хувийг дотоодоос хангаж байгаа бол 2019 онд одоогийн хүчин чадлыг 40 хувиар нэмэгдүүлж, нийт хэрэглээний 14 хувийг дотоодоос хангах боломж бүрдэх юм. Цаашид дунд, урт хугацаандаа шинэ ургацын нарийн ногооны импортыг бүрэн бууруулж, дотоодын хэрэгцээг хангахаар төлөвлөж байна.

Түүнчлэн, Засгийн газар "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөрийг баталж, орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, нэмүү өртөг шингэсэн, олон улсын чанар, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, гадаад, дотоод худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн импортыг орлох, экспортын чиг баримжаатай 100 үйлдвэрийг 21 аймагт байгуулах зорилт тавин ажиллаж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд 21 аймагт шинээр 100 үйлдвэр байгуулагдах бөгөөд 32 хувь нь хөнгөн үйлдвэр, 39 хувь нь хүнсний үйлдвэр, 29 хувь нь бусад салбарт хамаарч байна.

2.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж байгаа бөгөөд мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төсөл хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд БНХАУ-ын Засгийн газраас олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих, технологийн шинэчлэл хийх төсөл"-ийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тус зээлийн хөрөнгөөр мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд техник технологийн шинэчлэл хийх, олон улсын стандартын шаардлагад нийцсэн, өдөрт 150 бод, 1000 бог мал төхөөрөх, өдөрт 20 тн махыг дулааны аргаар боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг 4 байршилд бүсчлэн байгуулснаар махны экспортыг нэмэгдүүлэх боломжтой болно. Улсын төсвийн 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар өдөрт 1,000 толгой бог, 200 толгой бод төхөөрөх хүчин чадалтай, 1,000 тонны багтаамжийн хөргүүртэй орон нутгийн өмчит "Өв мийт продактс"ХХК-ийг 2017 онд Өвөрхангай аймагт байгуулсан. Үйлдвэр хэвийн ажиллагаанд орсноор шинээр 16-18, гэрээт 35 ажлын байр бий болно.

Мөн мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллаж байна. Тухайлбал, адууны махны экспорт 26.1 мянган тоннд хүрч үнийн дүнгээр нийт 44.5 сая ам.долларын орлого болж орлогын хэмжээ өмнөх оноос 3 дахин нэмэгдсэн бол хонь, ямааны махны экспорт 2.6 мянган тонн болж үнийн дүнгээр 8.3 сая ам.долларын орлого орж өмнөх оноос 22.8 дахин нэмэгдсэн байна. Цаашид махны чиглэлийн үйлдвэрүүдийг ашиглалтад оруулснаар, мах, махан бүтээгдэхүүний экспорт эрчимтэй өсөхөөр байна.

Түүнчлэн, ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын орлогыг нэмэгдүүлэх зорилтыг хангах бодлогын хүрээнд Засгийн газар "Ноолуур" хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлж, ноолуурын түүхий эдийн экспортыг бууруулан эцсийн бүтээгдэхүүний экспортыг

нэмэгдүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд угаасан ноолуурын экспорт 2021 онд 2600 тонн болж 2017 онтой харьцуулахад 2 дахин буурах бол харин самнасан ноолуурын экспорт 1500 тоннд хүрч 2.7 дахин, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2200 мянган ширхэгт хүрч 2.4 дахин нэмэгдэж, шинээр 3500 ажлын байр бий болохоор байна. Засгийн газраас сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж ажилласны үр дүнд сүлжмэл бүтээгдэхүүний экспортын хэмжээ ихээхэн нэмэгдээд байна. Тухайлбал, сүлжмэл пальтоны экспорт 2017 онд 49.5 мянган ширхэгт хүрч өмнөх оноос 1.7 дахин нэмэгдсэн бол тус бүтээгдэхүүний экспортын орлогын хэмжээ 5.9 сая ам.долларт хүрч өмнөх оноос 2.4 дахин нэмэгдсэн байна. Мөн сүлжмэл цамц бүтээгдэхүүний экспорт 2017 онд 274.6 мянган ширхэгт хүрч өмнөх оноос 27 хувиар нэмэгдсэн бол тус бүтээгдэхүүний экспортын орлого 12.7 сая ам.долларт хүрч өмнөх оноос 21.9 хувиар өссөн байна. Цаашид сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тогтмол дэмжсэнээр эдгээр бүтээгдэхүүний экспортын орлого нэмэгдэх төлөвтэй байна.

2.3. Мөн иргэний нисэхийн үйлчилгээнд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, дамжин өнгөрөх нислэгийн тоог нэмэгдүүлж, навигацийн орлогын өсөлтийг хангаж байна. Энэ хүрээнд хөрш хоёр оронтой өгөгдөл дамжуулах сүлжээ байгуулах системийн техникийн холболтыг хийж, навигац бүхий замуудыг шинэчлэн тогтоосны үр дүнд манай улсын агаарын зайгаар 2017 онд нийт өнгөрөлтийн 110,953 нислэг, 7,910 олон улсын буулт, хөөрөлт үйлдэж өнгөрөлтийн нислэгийн тоо өмнөх оноос 11.8 хувиар, олон улсын буулт, хөөрөлт өмнөх оноос 18 хувиар тус тус өссөн үзүүлэлтэй байна. Агаарын орон зайг ашиглах арга хэмжээг эрчимтэй авч, хэрэгжүүлснээр дамжин өнгөрөх нислэгийн навигацийн орлого 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 147.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 27.4 хувиар өсөөд байна. Цаашид өнгөрөлтийн тоо, хөөрөх, буурах онгоцны тоог нэмэгдүүлэх замаар агаарын тээврийн салбараас орох орлогын хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Мөн "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын хүрээнд 2020 он хүртэлх эхний үе шатны зорилтыг хэрэгжүүлэх "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-ыг Засгийн газар баталсан. Уг бодлогын хүрээнд:

- Иргэдээ эрүүл, аюулгүй хүнсээр бүрэн хангаж, улмаар хөрш орнуудын эрчимтэй нэмэгдэж байгаа дундаж болон чинээлэг иргэдийн эрүүл хүнсний эрэлтэд нийцүүлэн хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлж, ХҮНС ЭКСПОРТЛОГЧ УЛС болох;

- Экспортын тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангах зөөлөн болон хатуу дэд бүтцийг хөгжүүлэх;

- Орчин үеийн мэдээллийн технологи, тээвэр, логистикийн дэд бүтэц, кластерыг хөгжүүлж, Аж үйлдвэржилтийн 4-р хувьсгалыг эхлүүлэх;

- Баялаг бүтээгчдийг дэмжих багц бодлого, хуулийн төслийг боловсруулан бизнесийн орчныг таатай болгох;

- Татвар, нийгмийн даатгал, авлига, хүнд суртал, тэгш бус харилцааг зохицуулах төр болон хувийн хэвшлийн зөвлөлдөх механизмыг бүрдүүлэх зэрэг 27 зорилтыг хэрэгжүүлэх болно.

Эдийн засгийн төрөлжүүлж, олон тулгууртай болгох зорилтыг хэрэгжүүлэх

хүрээнд Монгол Улсын хөрөнгө оруулалтын бодлогыг шинэчлэх ажлыг эхлүүлж, Монгол Улсын хөрөнгө оруулалтын шинэтгэлийн зураглал /Investment Refort Mapping/-ыг гаргаж байна. Монгол Улсад орж байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалтын 70 гаруй хувь нь уул уурхайн салбарт дангаар хийгддэг бөгөөд хөрөнгө оруулалтын шинэчилсэн бодлого, таатай орчныг бүрдүүлснээр хөрөнгө оруулалт хийгдэх салбаруудыг төрөлжүүлж, уул уурхайн бус салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах боломж бүрдэх юм. Монгол Улсын хөрөнгө оруулалтын шинэтгэлийн зураглал 2018 оны 4 дүгээр сард багтан гарах бөгөөд тус зураглалд Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломжтой салбарууд (уул уурхайгаас бусад) тэдгээрийн хөрөнгө оруулалт шингээх чадвар, боломжууд зэрэг нарийвчилсан судалгаа багтах юм.

***Асуулт 2.** Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байнгын бүтэц, тогтолцоо бий болсон эсэх. Тогтвортой хөгжлийн зорилтууд, түүний хэрэгжилтийн явцад хэрхэн хяналт тавьж, ямар дүн шинжилгээ хийх талаар.*

Хариулт. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг Улсын Их Хурлаас 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталж, 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болж мөрдөж эхлээд байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн дагуу Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг болох “Үндэсний хөгжлийн газар” байгуулагдан Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан улсын хөгжлийн цогц бодлогыг хариуцан ажиллаж байна.

Түүнчлэн, Засгийн газрын бүх яам, орон нутгийн Тамгын газруудын бүтцэд хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан газар, хэлтэс байгуулагдан Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг мөрдөн ажиллаж байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7.5-д “Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” гэж, мөн хуулийн 7.6-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 7.5-д заасан тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.” гэж хуульчилсан.

Мөн Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийж Улсын Их Хуралд танилцуулах талаарх зохицуулалтыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7.7-д “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд дөрвөн жил тутам хөндлөнгийн

үнэлгээ хийлгэх ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.” гэж, мөн хуулийн 7.8-д “Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээний тайланг Улсын Их Хуралд танилцуулна.” гэж хуульчилсан.

Асуулт 3. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр жил бүрийн улс, орон нутгийн төсөвт хүрэлцээтэй тусч байгаа эсэх талаар.

Хариулт. Улсын төсвийн төлөвлөлтийг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилтуудын хүрээнд төсвийн хөрөнгийн хязгаар, төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн боловсруулж Улсын Их Хурлаар батлан хэрэгжүүлж байна.

Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоолоор баталсан Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 18 бодлогын зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 136 арга хэмжээний 99 нь “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-тай уялдсан бөгөөд хөрөнгө шаардлагатай 53 арга хэмжээ байгаагаас 39 нь 2018 оны улсын төсөвт туссан байна. Тухайлбал,

1. **Эдийн засгийн тогтвортой хөгжлийн хүрээнд:** Хөдөө аж ахуйн салбарын зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээнд 2018 оны улсын төсөвт 75.2 тэрбум төгрөг, эрдэс баялгийн салбарын зорилтуудад 16.7 тэрбум төгрөг, дэд бүтцийн салбарын зорилтуудад 66.8 тэрбум төгрөгийг батлан хэрэгжүүлж байна.

2. **Нийгмийн тогтвортой хөгжлийн хүрээнд:** Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдлын зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд 1,915.7 тэрбум төгрөг, эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд 92.7 тэрбум төгрөг, мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн зорилтын хүрээнд 1180.2 тэрбум (1,041.9 тэрбум төгрөгийн урсгал зардал) төгрөгийг 2018 оны улсын төсөвт тусган хэрэгжүүлж байна.

3. **Байгаль орчны тогтвортой хөгжлийн хүрээнд:** Усны нөөцийн нэгдсэн менежментийн зорилтын хүрээнд 1.1 тэрбум төгрөг, экосистемийн тэнцвэрт байдлын зорилтын хүрээнд 17.2 тэрбум төгрөгийг 2018 оны улсын төсөвт батлан хэрэгжүүлж байна.

Асуулт 4. Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлж байгаа, хэлэлцэн батлуулсан салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөр, зорилтууд нь Тогтвортой хөгжлийн зорилтуудтай хэрхэн уялдаж байгаа талаар.

Хариулт. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т “... үндэсний хөтөлбөрийг төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд боловсруулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна” гэж, мөн хуулийн 17.2-т “Төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа эсэх, түүнд тусгагдсан төсөв, санхүүгийн тооцоолол, санхүүжилтийн эх үүсвэрийг санхүү,

төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно” гэж заасны дагуу салбарын дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын дагуу “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон бусад дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байдлыг Сангийн яам хянаж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг олгож байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 2 жил гаруй хугацаанд салбарын яамдаас боловсруулсан төрөөс баримтлах 3 бодлого, үндэсний хөтөлбөрийн 23 төслийг хууль, журмын дагуу Сангийн яам хянаж, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон бусад дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, баталж хэрэгжүүлж байна.

Түүнчлэн, бодлогын баримт бичиг нь урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилтуудтай уялдаж, тэдгээрийн хэрэгжилтэд үзүүлэх нөлөөг үнэлэх нэгдсэн аргачлалыг бодлого төлөвлөгчдөд зориулан Үндэсний хөгжлийн газраас боловсруулаад байна. Энэхүү аргачлалыг бодлого төлөвлөлтөд нэвтрүүлснээр шинээр боловсруулж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан Монгол Улс дунд хугацааны бодлогоор дамжуулан урт хугацаанд дэвшүүлсэн зорилтод хүрэхэд чухал түлхэц болох юм.

Улсын Их Хурлын 2016 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 17 бодлогын зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 118 арга хэмжээний 95 нь “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-тай уялдаж байгаа бол, Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 18 бодлогын зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 136 арга хэмжээний 99 нь “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-тай уялдсан байна.

***Асуулт 5.** Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын 2.2-т заасан “Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах” ажил хийгдсэн эсэх талаар.*

Хариулт. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 24 дүгээр хуралдаанаас Үндэсний хөгжлийн газарт Улсын Их Хурлын 2015 оны 105 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх чиглэл өгсний дагуу Үндэсний хөгжлийн газар нь хөгжлийн урт хугацааны бодлогын зорилтуудтай нийцэж байгаа байдалд өнөөгийн хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгүүдэд үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэж байгаа болно.

Монгол Улсад 1990 оноос хойш үндэсний, салбарын болон салбар дундын түвшинд урд, дунд, богино хугацааны нийт 487 хөгжлийн бодлогын баримт бичиг батлагдсанаас одоогийн байдлаар 162 нь хүчинтэй байна. Хугацааны хувьд эдгээр бодлогын баримт бичгүүдийн олонх нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн

тухай хууль болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлагдахаас өмнө батлагдсан учраас нэршил болон хугацааны хувьд уг хуулийн шаардлагыг хангахгүй, бодлогын зорилго, зорилтууд нь урт хугацааны бодлогын зорилго, зорилтод чиглээгүй, хоорондын уялдаагүй байна.

Хүснэгт 1: 1990 оноос хойш батлагдсан бодлогын баримт бичгийн ангилал

Нийт	487				
Хүчинтэй	162	Улсын Их Хурлын тогтоол	56	Үзэл баримтлал	5
				Бодлого	24
				Бодлогын үндэс	1
				Стратеги	3
				Үндсэн чиглэл	8
				Үндэсний хөтөлбөр	7
				Хөтөлбөр	3
				Төлөвлөгөө	3
				Чиглэл	1
				Жагсаалт	1
		Засгийн газрын тогтоол	106	Бодлого	6
				Стратеги	8
				Үндэсний хөтөлбөр	46
				Хөтөлбөр	27
				Дэд хөтөлбөр	2
				Мастер төлөвлөгөө	1
				Төлөвлөгөө	7
				Чиглэл	6
				Жагсаалт	2
				Төсөл	1
Зогссон	3				
Хүчингүй	66				
Дууссан	256				

Үндэсний хөгжлийн газраас бодлогын баримт бичгүүдийн уялдаанд үнэлгээ хийх, хянах ажлыг дараах байдлаар зохион байгуулж байна. Эхний ээлжид салбар тус бүрийн хөгжлийн бодлогын уялдаанд үнэлгээ хийх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор Үндэсний хөгжлийн газраас “Хөгжлийн бодлогын баримт бичгийн хоорондын уялдаанд үнэлгээ хийх аргачлал”-ыг боловсруулаад байна. Дээрх аргачлалыг Швед Улсын Стокгольмын Байгаль орчны Институтийн боловсруулсан дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтын хоорондын уялдааг шинжилсэн аргачлалд тулгуурлан боловсруулсан бөгөөд зөвхөн салбар, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгийг урт хугацааны бодлогын баримт бичиг буюу “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д нийцсэн байдалд үнэлгээ хийхээр хязгаарлалгүй, хөгжлийн бодлогын нэгдмэл, цогц байдлыг хангах зорилгын үүднээс дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хоорондын болон салбарын бодлогын баримт бичгийн хоорондын уялдаа зэргийг үнэлж болохуйц байдлаар боловсруулсан байна.

Төрийн захиргааны төв байгууллагуудын хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд дээрх аргачлалыг танилцуулах сургалтыг 4 болон 5 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөж байна. Цаашид Үндэсний хөгжлийн газар нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлох, хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхийг бэхжүүлэхэд холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагуудад аргачлалыг танилцуулах ажлыг шат дараатай гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Дээрх аргачлалыг ашиглан Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрийг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн байдлыг үнэлэх, хянах ажлыг бүх төрийн захиргааны төв болон бусад байгууллагын оролцоотой ажлын хэсэг байгуулан гүйцэтгэх бөгөөд Үндэсний хөгжлийн газраас энэхүү ажлыг 2018 оны 2 дугаар улиралд багтаан удирдан зохион байгуулж, үр дүнг танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Асуулт 6. *Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолд заасан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн байдалд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Улсын Их Хурлын холбогдох байнгын хороонд танилцуулж байх заалтын хэрэгжилтийн талаар.*

Хариулт. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7.5-д “Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” гэж, мөн хуулийн 7.6-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 7.5-д заасан тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.” гэж заасан.

Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны

байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хавсралт 1-д заасан "Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа"-ны дагуу төрийн захиргааны төв байгууллага нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, 2018 оны 12 дугаар сард Улсын Их Хуралд танилцуулахаар ажиллаж байна.

Асуулт 7. 2020 он гэхэд Тогтвортой хөгжлийн зорилтын нэгдүгээр үе шатанд тавигдсан зорилтуудыг бүрэн хэрэгжүүлж чадах эсэх талаар тодорхой хариултыг боловсруулж ирүүлэх талаар.

Хариулт. Тогтвортой хөгжлийн зорилтын I үе шатанд тавигдсан зорилтуудын хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолын дагуу дүгнэж 2018 оны 12 дугаар сард Улсын Их Хуралд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.

"Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"-ын зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд дараах томоохон ажлуудыг хийж тодорхой үр дүнд хүрсэн. Үүнд:

1. **Эдийн засгийн тогтвортой хөгжлийн хүрээнд:** Төсвийн сахилга батыг сайжруулах, төсвийн алдагдлыг бууруулах чиглэлд Олон улсын валютын сантай хамтран "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд төсвийн сахилга батыг сайжруулж, орлогын бааз суурийг нэмэгдүүлэн улмаар ДНБ-д эзлэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг бууруулах бодлого баримталж байна. Тухайлбал, ДНБ-д эзлэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ 2016 онд 15.3 хувьд хүрээд байсан бол 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6.4 хувь болж буурсан. Засгийн газраас төсвийн орлогын бааз суурийг бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлж орлогын түвшин жил бүр нэмэгдэхээр байгаа бол хэмнэлтийн зарчим, "Нэмсэн бол хас" зарчмыг хуульчилсны үр дүнд зардлын хэмнэлтийг жил бүр хийж, зардал ихээр нэмэгдэх эрсдэлийг бууруулах боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд улсын төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ тогтмол буурч, 2020 он гэхэд тогтвортой хөгжлийн зорилтдоо хүрэхээр хүлээгдэж байна.

Мөн Монголбанкны гаргасан судалгаагаар санхүүгийн зах зээлд арилжааны банкуудын эзлэх хувь 2013 онд 96.8 хувь байсан бол жил бүр дараалан буурч 2016 онд 95.5 хувьд хүрсэн. Санхүүгийн зохицуулах хорооноос хийсэн судалгаагаар 2017 онд банкнаас бусад санхүүгийн бүх салбарт өндөр өсөлт гарсан байна. Тухайлбал, хөрөнгийн зах зээл, даатгал, банк бус санхүүгийн байгууллагын салбар дунджаар 25 хувьтай өссөн байна. Тэр дундаа үнэт цаасны салбарт зах зээлийн нийт үнэлгээ 2.4 их наяд төгрөгт хүрч 2016 оноос 65.9 хувиар өсөөд байна. Ойрын жилүүдэд хаалттай олон компаниуд хувьцаат компанийн хэлбэрт шилжиж хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах төлөвлөгөөтэй байгаагаа Санхүүгийн зохицуулах хороонд илэрхийлээд байна. Иймээс хөрөнгийн зах зээлийн санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээ нэмэгдэхээр хүлээгдэж байна.

Түүнчлэн, гадаад зах зээлд бүртгэлтэй уул уурхайн салбарын дотоодын хувьцаат компаниуд давхар бүртгэлтэйгээр хөрөнгийн захаас хөрөнгө босгох төлөвлөгөөтэй байна. Мөн төрийн өмчит томоохон компаниудын тодорхой хувийг хөрөнгийн зах зээл дээр борлуулахаар хүлээгдэж байгаа нь хөрөнгийн зах зээл хөгжих нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

Хөгжлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, гадаад, дотоод өрийн удирдлагын зохистой тогтолцоог бий болгон төлөвшүүлэх зорилтын хүрээнд гадаад өрийн асуудлыг эдийн засагт дарамт учруулахгүй байхаар бүтцийн өөрчлөлтийг хийгээд байна. Тухайлбал, Монгол Улсын Хөгжлийн банкнаас Засгийн газрын баталгаатайгаар 2012 онд гаргасан 580 сая ам.долларын бондын 82.07 хувийг Засгийн газрын 7 жилийн хугацаатай, 8.75 хувийн хүүтэй Хуралдай бондоор сольж, үлдэгдэл 124 сая ам.долларыг хугацаанд нь амжилттай төлж дуусгасан. Мөн 5.5 жилийн хугацаатай, 5.625 хувийн хүүтэй 800 сая ам.долларын Гэрэгэ бондоор 2018 оны 1 дүгээр сард төлөгдөх 500.0 сая ам.долларын Чингис бондын 74.5 хувь, 2018 оны 6 дугаар сард төлөгдөх 1.0 тэрбум юанийн Дим сам бондын 9.5 хувийг тус тус буцаан худалдан авч, Чингис бондын үлдэгдэл хэсгийг Гэрэгэ бондын эх үүсвэрээр хугацаанд нь төлж барагдуулаад байна. Гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь 2016 онд 68.2 хувьтай байна. Эдийн засгийн өсөлт ирэх жилүүдэд 5-6 хувь байхаар төсөөлөгдөж байгаа нь гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь буурах нөхцөлийг бүрдүүлж байна.

2. *Нийгмийн тогтвортой хөгжлийн хүрээнд:* “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-үүдийг 2017 онд батлан хэрэгжүүлж 51319 иргэнийг хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 46.7 тэрбум төгрөгийг зарцуулснаар 9385 байнгын ажлын байр, 16328 түр ажлын байр шинээр бий болж ажилгүйдлийн түвшин 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар 7.3 хувьд хүрээд байгаа нь 2016 оны мөн үеэс 1.3 нэгжээр (8.6 хувиас) буурсан байна.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог сайжруулах үүднээс Эрүүл мэндийн даатгалын санг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн бие даан үйл ажиллагаагаа явуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас Эрүүл мэндийн сайдын багцад холбогдох орон тоо, зардал, хөрөнгө болон орлого, эх үүсвэрийн хамт шилжүүлээд байна.

Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах хүрээнд элэгний вируст хепатитийн халдварыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд нийт 353,445 хүн амыг хамруулаад байна. С вирусын халдварын эсрэг эмчилгээнд 2017 оны байдлаар нийт 20,288 даатгуулагч хамрагдаад байгаа бөгөөд хепатитийн В вирус илрээгүй нийт 73,869 иргэдийг сайн дурын дархлаажуулалтад хамруулаад байна. Мөн эх орондоо эмчлэгдэхгүй байсан 9 төрлийн өвчнийг эх орондоо эмчилдэг болж даатгуулагчид үзүүлэх өндөр өртөг бүхий мэс заслын тусламж, үйлчилгээнд шаардагдах зарим эмнэлгийн хэрэгсэл, протезийн зардлыг даатгалын сангаас олгож байна.

2017 онд эхийн эндэгдлийн 20 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 26.9 промиль байгаа нь 2016 онтой харьцуулахад 21.7 буюу 18 тохиолдлоор буурсан байна. Нялхсын эндэгдлийн 1,009 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 13.6 промиль, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 1,244 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 16.7 промиль байгаа нь өмнөх оныхоос 306 болон 384 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2017 оны байдлаар 256720 хүүхэд буюу 10 хүүхэд тутмын 8 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулснаар хамран сургалтын бохир жин 82.7 хувьд хүрээд байна. Улсын төсөв, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр болон концессын гэрээгээр 2017 онд нийт 2525 хүүхдийн хүчин чадал бүхий 24 цэцэрлэг ашиглалтад орсон бол гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр нийт 675 хүүхдийн хүчин чадал бүхий 8 цэцэрлэгийг ашиглалтад оруулсан. Мөн 2017 онд нийт 12440 хүүхдийн хүчин чадалтай 22 сургуулийг шинээр ашиглалтад оруулан 500 хүүхдийн хүчин чадалтай 4 сургуулийн дотуур байр, 640 хүүхдийн хүчин чадалтай 2 спорт заал усан бассейны барилга ашиглалтад оруулаад байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардалд 2017 оны улсын төсөвт 10.3 тэрбум төгрөг баталсан нь улсын төсвийн 0.15 хувийг эзэлж байна. Эрдэм шинжилгээний ажлын зардал өмнөх оныхоос 1.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нэгж судлаачид ноогдох эрдэм шинжилгээний зардал 4.66 сая төгрөг болоод байна.

3. Байгаль орчны тогтвортой хөгжлийн хүрээнд: Засгийн газрын 2017 оны 91 дүгээр тогтоолоор Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн цэсийг 743 мянган га талбайгаар, Ноён уулын байгалийн нөөц газрыг 11 мянган га, Ноён уулын дурсгалт газрыг 650 мянган га талбайгаар хилийн заагийг тогтоосон. Нийт 3 аймгийн 3 сумын 754 мянган га буюу нийт газар нутгийн 0.44 хувийг тус тус улсын тусгай хамгаалалтад авч, тусгай хамгаалалттай нийт газар нутгийн хэмжээг 17.8 хувьд хүргэсэн.

Дорнод аймгийн Халх гол сум, Төв аймгийн Зуунмод сум, Увс аймгийн Бөхмөрөн суманд нийт 3 хөв цөөрөм барьж ашиглалтанд оруулсан. Увс аймгийн Улаангом сумын Тэрэм хадны суваг, Тариалан сумын Галданбошигтын хөвийн сувгийг тус тус сэргээн засварласан, Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд хөв байгуулах зураг төслийн ажил хийгдээд байна.

Ойт хээрийн бүсэд экологийн ач холбогдол бүхий шилмүүст модоор 280 га талбайг ойжуулах ажлыг 2017 онд хийж гүйцэтгэсэн. Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Их-Уул сумдад 40 га газар, Завхан аймгийн Тосонцэнгэл, Их-Уул, Тэлмэн сумдад 70 га газар, Сэлэнгэ аймгийн Мандал суманд 10 га газар, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд 20 га газар, Улаанбаатар хотын ногоон бүсэд 30 га газар нийт 170 га газарт ойжуулалт хийх ажлыг гүйцэтгэсэн. Ойн нөхөн сэргээлтийн ажлыг нийт 2074.2 га-д хийж гүйцэтгэсэн. Улсын төсвийн хөрөнгөөр 891 га, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1183.2 га, нөхөрлөлүүд 400 га, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр 1197.1 га ойжуулалт хийж нийт 3672.1 га-д ойг нөхөн сэргээсэн байна.

Түүнчлэн, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд урт хугацааны зорилтуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд түлхүү анхаарч, салбарын бодлогын уялдаа холбоог ханган шаардлагатай арга хэмжээг

тодорхойлох шаардлага үүсээд байгаа билээ. Иймд Үндэсний хөгжлийн газарт “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан хангахад чиглэсэн дунд хугацааны хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд болон “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ийг хэрэгжүүлэх салбарын уялдаа холбоог хангасан дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулах зорилгоор эдийн засгийн бүтээмжийн голлох салбаруудын тэргүүлэх зорилтуудыг тодорхойлох ажил хийгдэж байгаа бөгөөд эхний ээлжид мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, хүнд үйлдвэрлэл, аялал жуулчлал, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын зорилтуудыг холбогдох яам, агентлаг, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачдын оролцоо, хамтын ажиллагаатайгаар тодорхойлон ажиллаж байна.

Цаашид дэд бүтэц, нийгэм, байгаль орчны салбаруудын тэргүүлэх зорилтуудыг тодорхойлох ажлыг хийхээр төлөвлөөд байна. Дээрх салбарын зорилтуудыг Үндэсний хөгжлийн газар дээр байгуулж байгаа Ерөнхий тэнцвэрийн (ССЕ) загварт оруулан тооцоолох бөгөөд бодлогын тэргүүлэх зорилтуудын хоорондоо уялдах байдал, гарах үр дүнд үндэслэн эдийн засгийн бүтцийг олон тулгууртай болгохын тулд аль салбарыг төрөлжүүлж хөгжүүлэх шаардлагатай болохыг тодорхойлох юм.

---ooOoo---

"МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030"-ЫН ЗОРИЛТУУДЫН НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ ХҮРЭХ ТҮВИН, САЛБАРЫН ЯАМДЫН ТӨЛӨВЛӨСӨН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МУТХУБ-2030	САЛБАРУУД	ЗОРИЛТУУД	Шалгуур үзүүлэлт	Салбарын яамдаас төлөвлөсөн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүд		"МУТХУБ-2030"-ын зорилтуудын I үе шатны хүрэх түвшин	Зөвлөх
				Суурь түвшин 2016 он	Хүрэх түвшин 2020 он		
2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	2.1.1.Хөдөө аж ахуйн салбар	Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын уямын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, бэлчээрийн давцад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохицтой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологийг олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлэнэ. Зорилт 2. Хүн амын төлөрөл, зах зээлийн эрэлтийг хангалзан эрчимжсэн мал аж ахуйг түгшүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхийг эд, бүтээгдэхүүний бэлтгэл нийлүүлэлт, худалдалт, тээвэрлэлтийн гүйцэтгэл хөгжүүлдэг. Зорилт 3. Хөрсний уржлал шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгаваны хамнаалттай, үр ашгтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэглээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэнэ. Зорилт 4. Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологийн, эрчим хүчээр хангах, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх сэнхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэнэ.	Мал амьтны өвчингүй статустай нутгийн эзлэх хувь	ХХААХҮЯ-аас мэдээлэл авах	ХХААХҮЯ-аас мэдээлэл авах	10 хувь	Мэдээлэл авах
			Мал сүргээт өндөр ашиг шимт малын эзлэх хувь	ХХААХҮЯ-аас мэдээлэл авах	ХХААХҮЯ-аас мэдээлэл авах	3 хувь	Мэдээлэл авах
			Үр тарианы дэвшилтэт технологи нэвтрүүлэх ажлын хувь	ХХААХҮЯ-аас мэдээлэл авах	ХХААХҮЯ-аас мэдээлэл авах	70 хувь	Мэдээлэл авах
			Цахилгаан эрчим хүч, техник технологийн болон санхүүгийн дэмжлэг авсан малчдын эзлэх хувь	ХХААХҮЯ-аас мэдээлэл авах	ХХААХҮЯ-аас мэдээлэл авах	50 хувь	Мэдээлэл авах
2.1.2. Аялал жуулчлалын салбар		Зорилт 1. Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно.	Гадаадын жуулчны тоо	0.4 сая	1.0 сая	1.0 сая	ЗГ-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЗЭНХҮ-тад үндэслэн боловсруулсан

2.1.3.Аж үйлдвэрийн салбар	Зорилт 1.Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.	Арьс, шир, ноос, ноолуур зэрэг түүхий дэний бүрэн боловсруулалтын хувь	30 хувь	60 хувь	60 хувь	3г-ийн 2018 оны 36 дугаар тогтоолоор баталсан Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрт үндэслэн боловсруулсан
	Зорилт 2.Хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, ирээдүйг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Үйлдвэрлэлийн аргаар боловсруулах махны эзлэх хувь	8 хувь	33 хувь	30 хувь	3г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХҮ-тэд үндэслэн боловсруулсан
	Зорилт 3.Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэглээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.	Шатахууны хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангах хувь	УУХҮҮ-наас мэдээлэл авах		20 хувь	Мэдээлэл авах
2.1.4.Эрдэс баялгийн салбар	Зорилт 4.Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууллажуйн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэглээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.	Жилд ган бөмбөгөг, тээрмийн хуяг, бусад эд анги үйлдвэрлэх хүчин чадал	40 мянган тн	50 мянган тн	100.0 мянган тн	3г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХҮ-тэд үндэслэн боловсруулсан
	Зорилт 1.Геологийн салбарын хөгжлийг дэмжинэ.	Нийт нугаг дэвсгэрт эргийн ажилд хийгдсэн газрын эзлэх хувь	34.6 хувь	41 хувь	40 хувь	3г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХҮ-тэд үндэслэн боловсруулсан
	Зорилт 2.Ил тод, харилцалгатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	Говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах	Эхлүүлэх	55 хувь	100 хувь	УХОХ-ийн төсөлд туссан Тавантолгойн 450 МВ цахилгаан станцын санхүүжилтын дүнгээр тооцсон болно.
2.1.5.Дэд бүтцийн салбар	Зорилт 1.Эрчим хүчний хэрэглээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.	Эрчим хүчний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах хувь.	ЭХЯ-аас мэдээлэл авах	ЭХЯ-аас мэдээлэл авах	85 хувь	3г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХҮ-тэд үндэслэн боловсруулсан
	Зорилт 2.Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангана.	Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	ЭХЯ-аас мэдээлэл авах	ЭХЯ-аас мэдээлэл авах	20 хувь	Мэдээлэл авах
	Зорилт 3.Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, логистикийн сүлжээг хөгжүүлнэ.	Шингээр нэмэгдүүлэх олон улсын чанартай хатуу		1652 км	1600 км	3г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХҮ-тэд

2.2.НИЙГЭМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	2.2.1.Хүртээмжтэй өсөлт ба	2.1.8.Микро эдийн засгийн бодлого	Зорилт 4.Хэрэглэгчийн эрэлт, хэрэглээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ.	Хүчинтэй автозамын урт	ЗТХЯ-аас мэдээлэл авах	ЗТХЯ-аас мэдээлэл авах	100 хувь	Мэдээлэл авах	Үндэслэн боловсруулсан
			Зорилт 5.Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	МУ-н хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн төсөл боловсруулах	БХБЯ-аас мэдээлэл авах	БХБЯ-аас мэдээлэл авах	100 хувь	Мэдээлэл авах	
			Зорилт 6.Хот, суурин газрын бие давсан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилгог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаалаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ.	Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулах	БХБЯ-аас мэдээлэл авах	БХБЯ-аас мэдээлэл авах	100 хувь	Мэдээлэл авах	
			Зорилт 7.Мэдээллийн технологийг, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлж, үндэсний хиймэл дагуул хөөрлөнө.	Хүн амын интернетэд холбогдох хувь	ХХМТГ-аас мэдээлэл авах	ХХМТГ-аас мэдээлэл авах	70 хувь	Мэдээлэл авах	3г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЗЭНХҮ-тэд үндэслэн боловсруулсан
			Зорилт 1.Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулна.	Төсвийн алдагдлын ДНБ-нд эзлэх хувь	(15.2) хувь		2 хувь		
			Зорилт 2.Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлнэ. Санхүүгийн зах зээлд банкны бүс санхүүгийн байгуулалын гүйдэлтэй үүргийг нэмэгдүүлж, арилжаваны банк, хөрөнгийн зах зээл, давагталын зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэнэ.	Хөрөнгийн зах зээлийн эзлэх хувь	СЯ-аас мэдээлэл авах	СЯ-аас мэдээлэл авах	10 хувь	Мэдээлэл авах	
			Зорилт 3.Хөгжлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, гадаад, дотоод өрийн удирдлагын зохистой тогтолцоог бий болгон төлөвшүүлнэ.	Гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь	СЯ-аас мэдээлэл авах	СЯ-аас мэдээлэл авах	58.6 хувь	Мэдээлэл авах	
2.1.7.Бизнесийн тавтай орчин	Зорилт 1.Худалдаа, үйлчилгээг хөгжүүлж, экспорт, импортын барууны тээвэрлэлтийн логистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хэлбэршүүлэх, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төлөлдөршүүлнэ.	Гадаад худалдаанд зарцуулж буй хонгог	ГХЯ-аас мэдээлэл авах	ГХЯ-аас мэдээлэл авах	25 хонгог	Мэдээлэл авах			
	Зорилт 1.Ядуурлын бүх төрлийг зүгс болгоно.	Ядуурлын түвшин	ХНХЯ-аас мэдээлэл авах	ХНХЯ-аас мэдээлэл авах	18 хувь	Мэдээлэл авах			

Нийгмийн тэгш байдал	Зорилт 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зохицгоо хөдөлмөр, хүний бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлдэг, ажиглалтын түвшинг бууруулна.	Ажиглалтын түвшин	9 хувь	6 хувь	6 хувь	3Г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХУ-гэд үндэслэн боловсруулсан
	Зорилт 3.Үндэсний онцлог, хүн амын насны бүтцийн өөрчлөлтөд нийцүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэхийц нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.	Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлэх	ХНХЯ-аас мэдээлэл авах	ХНХЯ-аас мэдээлэл авах	100 хувь	3Г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХУ-гэд үндэслэн боловсруулсан
2.2.2.Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтоцоо	Зорилт 1.Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана.	Хүн амын дундаж наслалт	69.6	ХНХЯ-аас мэдээлэл авах	71	3Г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХУ-гэд үндэслэн боловсруулсан
	Зорилт 2.Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.	Эхийн эндэгдлийн түвшинг 100,000 амьд төрөлт бүрт бууруулах промилль	48.6	25	25	3Г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХУ-гэд үндэслэн боловсруулсан
	Зорилт 3.Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын нэрвэгчид, оролцоотой нэгдэл үйл ажиллагаанд түлгүүрлэн бууруулна.	10,000 хүн амд ногдох хорт халдварас шалтгаалсан нас баралт	13.3	10.5	10.5	3Г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХУ-гэд үндэслэн боловсруулсан
	Зорилт 4.Халдварт өвчний таацалт, сэргийлэлт, болон байдлыг хангах, харин ярга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадварыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.	Төлөмт дөрхөлөөжүүлэлтийн хамралтын хувь	98.5 хувь	98.5 хувь	98.5 хувь	3Г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХУ-гэд үндэслэн боловсруулсан
2.2.3.Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн	Зорилт 1.Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ.	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдлын түвшин	80.8 хувь	83.9 хувь	70 хувь	3Г-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХУ-гэд үндэслэн боловсруулсан
	Зорилт 2.Монгол иргэнийг төлөвшүүлэх ерэнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна.	Боловсролын олон улсын чанарын үнэмлэхэнд хамрагдах бэлтгэлийг хангах	БСШУСЯ-аас мэдээлэл авах	БСШУСЯ-аас мэдээлэл авах	100 хувь	Мэдээлэл авах
	Зорилт 3.Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн өмнөх боловсрол, сургалтын багшлах болгож, төгсгөлд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлнэ.	Мэргэжлийн боловсрол, сургалтын багшлах боловсон хүчнийг чадваруулах	БСШУСЯ-аас мэдээлэл авах	БСШУСЯ-аас мэдээлэл авах	100 хувь	Мэдээлэл авах
	Зорилт 4.Тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно.	Дээд боловсролын тогтолцоог тэгш, хүртээмжтэй чанартай болгох	БСШУСЯ-аас мэдээлэл авах	БСШУСЯ-аас мэдээлэл авах	100 хувь	Мэдээлэл авах

		Зорилт 5. Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан урддаар хангах, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ.	ШУ, технологийн судалгааны санхүүжилт ДНБ-д эзлэх хувь	0.11 хувь	0.5 хувь	2.0 хувь	ЭГ-ийн 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан ЭЗНХГ-гэд үндэслэн
2.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	2.3.1. Усны нөөцийн нэгдсэн менежмент	Зорилт 1. Усны нөөцийг хамгаалж, хомсдолгоос сэргийлнэ.	Гол мөрийн эхийг хамгаалганд авах хувь	БОАЖҮ-аас мэдээлэл авах	БОАЖҮ-аас мэдээлэл авах	50.0 хувь	Мэдээлэл авах
		Зорилт 2. Эрүүл ахуйн шавардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Ундны усавар хангагдсан хүн амын эзлэх хувь	БОАЖҮ-аас мэдээлэл авах	БОАЖҮ-аас мэдээлэл авах	80.0 хувь	Мэдээлэл авах
	2.3.2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох	Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чөдөвхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ.	Гамшгийн эрсдэлийн менежментийг чөдөвхийг бэхжүүлэх	БОАЖҮ-аас мэдээлэл авах	БОАЖҮ-аас мэдээлэл авах		Мэдээлэл авах
		Зорилт 2. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрсгөрөгчийн ялгарлыг бууруулна.	Хүлээмжийн хийг бууруулах хувь	БОАЖҮ-аас мэдээлэл авах	БОАЖҮ-аас мэдээлэл авах	2.0 хувь	Мэдээлэл авах
2.3.3. Экосистемийн тэнцвэрт байдал	Зорилт 1. Байгалийн унаган төрх, биологийн олон анз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.	Улсын тусгай хамгаалалттай газрын эзлэх хувь	0.018 хувь	0.021 хувь	25 хувь	БОАЖҮ-аас мэдээллийг нийтлүүлэх	
	Зорилт 2. Хот сууринны төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дэдлэг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хөг хөгжлийн менежментийг сайжруулна.	Улаанбаатар хотыг утаалуй болгох, ногоон байгууламжийн эзлэх хувийг	Улаанбаатар хотос мэдээлэл авах	Улаанбаатар хотос мэдээлэл авах	15 хувь	Мэдээлэл авах	

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР